МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 21 өдөр | Дугаар 27 | Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14^1 дүгээр зүйлийн 14^1.2, 14^1.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг доор дурдсанаар баталсугай:

Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

1/Сангийн сайд

2/Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд

3/Эрүүл мэндийн сайд

Даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:

1/Б.Алтанхуяг-Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга

2/Т.Баясгалан-Шинжлэх Ухааны Академийн харьяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

3/С.Эрдэнэбат-Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч

Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

1/Ж.Гэрэлмаа-Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн

2/Ш.Зоригоо-Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч

3/Н.Одонгуа-Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР